МУЕА-ын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн
А/70 дугаар тушаалын хавсралт 2

## ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр:Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн хөгжлийн алба
Тайлант хугацаа: 2024 оны санхүүгийн тайлангийн заврын аудит
ХҮСНЭГТ А: Эрсдэлтэй АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

| Д/д | АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (мянган төгрөг) | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | |
| 1 | МГТ | Нийт зардал | МГТ-нд Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг дутуу илэрхийлсэн. | 23,141.60 | үгүй | Тийм | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" батламж мэдээлэл хангахгүй байна. | Алдаа | Залруулах зөвлөмж | Үгүй | Залруулах зөвлөмж |
| 2 | Ажил гүйлгээний анги | Мөнгөн хөрөнгө | Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй. | 35,314.28 | Үгүй | Тийм | УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8 ""ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" 38 дугаар зүйлийн 38.1 "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна." | Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой | Зөвлөмж | Үгүй | Зөвлөмж |
| | | Дүн | | 58,455.9 | | | | | | | | |

**Бэлтгэсэн:**

Аудитор Л.Одонтуяа Огноо:

**Хянасан:**

Аудитын менежер Д.Отгонбаяр Огноо:

Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Огноо:

**Танилцаж зөвшөөрсөн:**

Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн хөгжлийн алба
Дарга /Ж.Мөнхзориг/ Огноо:

Нягтлан бодогч /Л.Түвшинбат/ Огноо: